

ОЙРАД ЕРӨӨЛИЙГ ЦУГЛУУЛЖ ХЭВЛҮҮЛСЭН ОНОО АЛДАА

Товч агуулга: Тус өгүүлэлд, Шинжааны ойрад монголчуудын ерөөлийн цуглуулж хэвлүүлсэн түүхийг олсон амжилт ба оршисон асуудал гэх хоёр талд хуваан задлан шинжилж, шинжааны ойрад монголын ерөөлийн цуглуулга хэвлэлийн ажил нь хэдийгээр 20 дугаар зууны наяд оноос эхэлж, зохих амжилт олсон боловч, бичгийн соёлын уламжлалын аргаар ерөөлийг засан өөрчлөн хэвлүүлэх, тэмдэглэсэн газар орон болон ерөөлч, цуглуулагчтай холбогдох мэдээ занги дутуу ба зан үйлийн уламжлалаас салсан нүцгэн ерөөлийн текст хэвлүүлэх зэрэг асуудал оршсон байна гэж үзэв.

Түлхүүр үг: Шинжааны ойрад монгол, ерөөл, цуглуулга хэвлэл.

Mirelikhan Nadmidtseren
 Inner Mongolia University
 Hohhot, China

ON THE COLLECTION AND PUBLICATION OF THE BLESSINGS OF OIRATS

Abstract: This article explores the history of collecting and studying the blessings of the Oirats of Xinziang. Work on the publication of the collection was started in the 1980s. Successes were achieved in studying the methodology of recording and publishing authentic texts.

Key words: Oirats of Xinziang, blessing, collection and publication.

Ойрад монголчууд голдуу одоогийн БНХАУ-ын Шинжаан Уйгарын Өөртөө Засах Орон, Хөхнуур муж, Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Ганьсу муж, Оросын Холбооны Халимаг Улс ба Монгол Улсын Ховд, Баян-Өлгий, Увс зэрэг аймгийн өргөн уудам нутаг дэвсгэрт тархан сууж, суурьшин амьдарч байдаг.

Ойрад монголчууд бол “Жангар”, “Гэсэр”, үлгэр тууж, дуу, домог, ерөөл магтаал, зүйр цэцэн үг, ертөнцийн гурав зэрэг аман бүтээлийн уламжлалаар баян ард түмэнболно. Эдгээр аман уламжлалын баялаг өв нь дотоод гадаадын олон эрдэмтний анхаарлыг татаж, 19 дугаар зууны эхнээс сурвалжлуулан цуглуулагдаж, эмхтгэгдэн хэвлэгдэж, судлагдан шинжлэгдсэн бөгөөд өнөө үргэлжлэн монгол аман соёлын чухал нэг судалгааны сэдэв ба эрдэм шинжилгээний халуурлын цаг болох хандаштай байна. Доор бид монгол аман бүтээлийн доторх биеэ даасан нэг хэлбэр болох ерөөлийн шинжааны ойрадын дундаас цуглуулагдан хэвлүүлэгдсэн байдал ба түүний олсон амжилт ба оршсон асуудлын тухай дөхөм өгүүлье.

Нэг. Олсон амжилт

(Нэг) Тусгай эмхтгэлийн хэвлэгдсэн байдал

Ойрад монголын ерөөл магтаалыг судлахад чухал эг хэрэглэгдхүүн бол 1980 онд, шинжаангийн ардын хэвлэлийн хорооноос тод өсгөөр хэвлүүлсэн “Ерөөл магтаал” [Ерөөл магтаал”, 1980] гэх ном болно. Тус ном нийт 140 нүүртэй ба бүтээлд орсон ерөөл нь агуулгын хувьд “гэрийн ерөөл”, “зус хадгийн ерөөл” зэрэг нийт 17 ерөөлийн текст орсон байна. Цуглуулагдсан газар орны хувьд шинжааны Баянголын Монгол Өөртөө Засах Жоу(аймаг)-гийн Хажин шиань (хошуу)-ы Баянбулаг, Ховогсайр Монгол Өөртөө Засах Шиань, Хар-Ус шиань зэрэг газар орны ерөөл байж, Цэрэн, Бадай, Тэвхийн Бямба, Шарын Тунид, Д. Бадам, Сү. Дорж зэрэг хүмүүнээс тэмдэглэжээ. Энэ нь шинжааны ойрад монголчуудын ерөөл магтаалын анхны тусгай хэвлэл болно.

Шинжааны ардын хэвлэлийн хорооноос 1980 онд хэвлүүлсэн “Ерөөл магтаал” гэх номын суурь дээр нэмж тод үсгээр 1983 онд хэвлүүлсэн “Ерөөл магтаал” [Ерөөл магтаал”, 1983] гэх ном бол шинжааны ойрадын ерөөл магтаалын цуглуулгын бас нэг биеэ даасан тусгай хэвлэл болно. Ном нь нийт 390 нүүртэй байж, агуулгын хувьд “гэрийн ерөөл”, “өвчүү цахих ерөөл”, “өөд барих ерөөл” зэрэг нийт 59 ерөөлийн текст орсон байна. Цуглуулагдсан газар орны хувьд, шинжааны Баянголын Монгол Өөртөө Засах Жоугийн Хажин шиань, Бостнуур шиань, Хамил аймгийн Бархөл Казах Өөртөө Засах Шиань, Борталын Монгол Өөртөө Засах Жоугийн Бордлоо шиань, Рашаан шиань, Жин шиань, Илийн Казах Өөртөө Засах Жоугийн Нялх шиань, Цавчаалын Шивээ Өөртөө Засах Шиань, Тарвагатай аймгийн Ховогсайр Монгол Өөртөө Засах Шиань, Хар-Ус шиань, Дөрвөлжин шиань зэрэг газар орныг хамарсан байна. Ерөөлийг Цэрэн, Бадай, До. Бадам, А. Цэвэгжав, Т. Балжинням, Чинзун, До. Өвөлжин, П. Кнээр, Батоку, Ж. Батнасан, Т. Орлогон, Тэвхийн Бямба, Тунид, Бу. Олцуу, Сү. Дорж, Жалцав, У. Пүрэвээ, Бу. Ням, С. Манж, Дамбаравжаа, Ням, Батоку, Дамар, Цока зэрэг хүмүүсээс тэмдэглэжээ. Тус бүтээл нь 1980 онд хэвлүүлсэн “Ерөөл магтаал” гэх тусгай хэвлэлийг

бодвол ерөөлийн төрөл зүйлээр олон, агуулгаар баян, хамарсан орон нутгаар өргөн, ерөөлчийн тоогоор олон байж, ойрад ерөөлийн уламжлал залгамжлалд гарын авлага болсон чухал бүтээл болсон байна.

Ойрад ерөөл магтаалын бас нэг тусгай хэвлэл бол Цэцэнмөнх, Гэрэлцэцэгийн эмхэтгэж найруулж, 1993 онд Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн “Ойрад монголын ерөөл магтаал” [Ойрад монголын ерөөл магтаал, 1993] гэх ном болно. Номд БНХАУ-ын ойрад монголчуудын төвлөрөн сууж байгаа Шинжаан Уйгарын Өөртөө Засах Орон, Хөхнуур муж, Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Ганьсу муж зэрэг газар орны ерөөл магтаалыг хамарч оруулсан байна. Тус бүтээлд, 1983 онд Шинжааны ардын хэвлэлийн хорооноос тод үсгээр хэвлүүлсэн “ерөөл магтаал” гэх ном дахь “архи цацах ерөөл”, “дээжийн ерөөл”, “энгийн цацлын ерөөл”, “гэрийн ерөөл” зэрэг 28 ерөөлийг тод үсгээс уйгаржин монгол үсэгт буулган хэвлүүлсэн байна.

Шинжааны ойрдын ерөөл магтаалын цуглуулга хэвлэлийн тухай хамаг анх илээр нийтлэж хэвлүүлсэн орон нутгийн тусгай хэвлэл бол 2010 оны 4 сард, Шинжааны сурган хүмүүжлийн хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн “Ховогсайрын ерөөл магтаалын эмхэтгэл” [Ховогсайрын ерөөл магтаалын эмхэтгэл, 2010] гэх ном болно. Тос ном нь нийт 347 нүүртэй байж, бага 32К-гийн зүсмээр уйгаржин монгол, тод монгол хоёр бичгээр зэрэгцүүлэн хэвлүүлсэн байна. Бүтээлд Ховогсайр нутагтай Т. Сумъя, На. Бууваа, П. Найхий, Ц. Цэмбэл, Содмонцэрэн, И. Норжим, Цавгийн Нааняраг, Ма. Намцэрэн зэрэг хүмүүсийн ерөөл магтаалыг цуглуулан хэвлүүлж, агуулгын хувьд ховогсайр нутгийн “гэрийн ерөөл”, “архи цацах ерөөл”, “сайд ноёдын ерөөл”, “бэр мөргүүлэх ерөөл” зэрэг нийт 94 ерөөлийн текстийг багтаажээ. Мөн ерөөлч Т. Сумъя, На. Буу, П. Найхий зэрэг гурван хүний төрсөн он жил, нутаг ус, амьдралын дөхөм өнгөрөлт зэргийг тэмдэглэн оруулсан нь хойшдын ерөөлчийн судлал, ерөөлийн аман уламжлалын газар орны онцлог зэргийг судлахад маш сайн эх хэрэглэгдэхүүн хангасан бүтээл болжээ.

Цу. Хүрэлбаатар, Ша. Хишигманлайн эмхэтгэн найруулж, Өвөр монголын ардын хэвлэлийн хорооноос 2014 онд хэвлүүлсэн “Цахар ардын ерөөл магтаалын чуулган” [Цахар ардын ерөөл магтаалын чуулган, 2014] гэх номдоо шинжааны цахаруудын ерөөл магтаалыг цуг багтаан оруулсан байна. Үүнд, шинжааны Борталын цахар нутгийн Чи. Пүрэвжав, Ба. Түвшинбат, Жалцав зэрэг хүмүүсийн “нялх хүүхдийн өлгийн ерөөл”, “хурммын ерөөл” гэх мэтийн нийт 28 ерөөлийн текстийг оруулжээ.

Цу. Хүрэлбаатарын эрхлэн найруулж, 2015 онд Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн “Цахрын шинэ ерөөл магтаал” [Цахарын шинэ ерөөл магтаал, 2015] гэх бүтээл шинжааны Борталын Га. Гомбын зохиосон “наян таван насны найрын ерөөл”, “өлгийн ерөөл”, нь. мтгайн зохиосон “давхар гэрийн ерөөл”, “цагааны ерөөл”, Түвшинбатын зохиосон “цахрын овооны ерөөл” зэрэг 25 ерөөлийг оруулж хэвлэсэн байна.

Шинжааны ойрадын ерөөл магтаалын цуглуулга эмхтгэлийн тухай хамаг анхны хувь хүмүүний ерөөлийн тусгаар хэвлэл бол шинжааны сурган хүмүүжлийн хэвлэлийн хорооноос 2016 онд тод үсгээр хэвлүүлсэн И. Норжимийн “Ерөөл магтаал-нэг нас, Ховогсайрын ардын аман зохиол” [Норжим, 2016] гэх бүтээл болно. Хамаг анхны бие даасан хувь хүмүүний ерөөлийн тусгай хэвлэл болохын хувьд, Ховогсайр нутагтай И. Норжим гуай өөрийн мэддэг ерөөл магтаалаа түүнтэй холбогдсон ёс явдалтай нь дагалдуулан хэвлүүлсэн байна. Нэн бодитойгоор хэлбэл тус бүтээлд “өлгийн ерөөл”, “үс‘ өрвөлгө’ авах ерөөл”, “морь онуулах ерөөл” зэрэг 23 гурван ерөөлийн текст орсон байна. Номд ерөөлөөс гадна, зохиогчийн өөр мэддэг магтаал, домог үлгэр, урт дуу, зүйр цэцэн үг зэргээ оруулж хэвлүүлсэн байна. Тус бүтээл нь зан үйл ба ерөөлийг хамтад нь авч үзсэн нь дээрх хэдэн тусгай хэвлэлээс ялгагдах онцлог болно.

(Хоёр) Аман уламжлал, зан үйлийн бүтээлд орсон байдал

Шинжааны ойрад монголчуудын ерөөлийн цуглуулга хэвлэл тусгай эмхтгэлээс гадна бусад аман бүтээлийн эмхтгэлд бас цуглуулагдан орсон байна.

Өвөр Монголын Их Сургуулийн Монгол хэл утга зохиолын салбараас эмхэтгэн, Өвөр монголын ардын хэвлэлийн хорооноос 1959 онд хэвлэсэн “шин жаны монгол ардын дуу шүлгүүд” [Шинжааны монгол ардын дуу шүлгүүд, 1959] гэх аман бүтээлийн ерөнхийлсөн хэвлэлд шинжааны ойрадын “гэрийн ерөөл”, “гэр авах ‘хуримлах’-ын ерөөл”, “шинээр гэрлэсэн хөвүүний ерөөл”, “морны ерөөл” зэрэг ерөөлийн 4 текст орж, энэ нь Хятад улс байгуулагдасны дараа, шинжааны ойрадын ерөөлийн цуглуулга хэвлэлийн эхлэл болсон гэж хэлж болно.

Нү. Зоригтойн эмхэтгэн найруулсан “Ховогсайрын монгол ардын аман зохиолын дээж” [Ховогсайрын монгол ардын аман зохиолын дээж, 2004] гэх номд Нү. Зоригтойн Ж. Зууний, Зөвний Дорж, Замдгийн Гомбожав, Б. Цэвэгжав зэрэг хүмүүсээс тэмдэглэж авсан “Ховогсайрын газар усны ерөөл”, “баян өндрийн тахилганы ерөөл” зэрэг ерөөл ба 1983 онд хэвлэгдсэн “ерөөл магтаал” гэх номд орсон Ховогсайрын “гал тайх ерөөл”, “тахилганы ерөөл” зэрэг нийт 19 ерөөлийн текстийг оруулж хэвлүүлсэн байна.

БНХАУ-ын Улс төрийн зөвлөлгөөний Монголхүрээ шианий салбар зөвлөлөөс эмхэтгэн найруулж, шинжааны Шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хорооноос 2011 онд тод үсгээр хэвлүүлсэн “Шинжааны өөлдүүдийн зан үйл” [Шинжааны өөлдүүдийн зан үйл, 2011] гэх номд Түрхийн Төрмөнх Монголхүрээ шианий Шат сумын Ма. Мөнхнасан, 76 дугаар тойргийн На. Олонбаяр нараас “өлгийн ерөөл”, “эдийн ерөөл”, “хараачийн ерөөл” зэрэг 15 ерөөлийг цуглуулж, тэдний товч намтартай хамт оруулан хэвлүүлжээ.

У. Тайваны буулган тайлбарласан “Жангарч Жуунаагийн гар бичмэлийн текст (нэг)” [Жангарч Жуунаагийн гар бичмэл текст, 2015]-дээ алдарт жангарч Жуунаагийн “нуувчийн ерөөл”, “магнайн морины ерөөл”, “хадаг зусын ерөөл” зэрэг 3 ерөөлийг оруулсан байна.

(Гурав) Сонин сэтгүүл дээр нийтлэгдсэн байдал

Шинжааны ойрадын ерөөлийн цуглуулга эмхтгэл нь дээрх ярьж өнгөрсөн бүтээлүүдэд орсноос гадна сонин сэтгүүл дээр ч цөөн бус нийтлэгдэн олны хүртээл болсон юм. “Шинжааны өдрийн сонин”-ы монгол хэвлэл дээр одоо болтол Буянтогтохын эмхэтгсэн “Цагаан сарын ерөөл” [Шинжааны өдрийн сонин, 1982], Га. Гомбын “Гурван булагт ерөөл” [Шинжааны өдрийн сонин, 1983], Ө. Чүлтэмийн “Ерөөл” [Шинжааны өдрийн сонин, 1983], У. Басангийн “Шинэ жилийн ерөөл” [Шинжааны өдрийн сонин, 1984] зэрэг нийт 33 ерөөлийн текст нийтлэгдсэн байна. “Хан тэнгэр” сэтгүүлд Бу. Мөнхийн эмхэтгсэн “хошуудын гэрийн ерөөл” [Хан тэнгэр, 1987], Даш өвгөнөөс тэмдэглэсэн “Зус хадгийн ерөөл”, “Хуримын ерөөл” [Хан тэнгэр, 1991] зэрэг 28 ерөөлийн текст орж, “Үүрийн цолмон” сэтгүүлд Т. Одын “Шинэ ерөөл” [Үүрийн цолмон, 1985] ба Сү. Доржийн эмхэтгсэн “Хажин шианий ардын ерөөлүүдээс” [Үүрийн цолмон” сэтгүүл, 1986] зэрэг 14 ерөөлийн текст тус тус оруулан нийтлэсэн байна.

Багцалбал, шинжааны ойрадын ерөөлийг тусгаар хэвлэл болгон хэвлүүлэх ажил 1980 оноос эхэлж, од болтол хэвлэгдсэн ерөөл магтаалын 4 боть тусгай хэвлэл, 3 боть бусад газар орны ерөөл магтаалын тусгай хэвлэлийн дотор нийт 274 шинжааны ойрадын ерөөлийн текст орж хэвлэгдэж, аман уламжлал-зан үйлийн 4 боть бүтээлд 41 ерөөл орж хэвлэгджээ. Мөн “Шинжааны өдрийн сонин” (монгол хэвлэл), “Хан тэнгэр”, “Үүрийн цолмон” зэрэг сонин сэтгүүл дээр 75 ерөөл орж тэмдэглэгдсэн байна.

Хоёр. Оршиж буй асуудал

Бидний ярьж өнгөрсөн ерөөлийн тусгай хэвлэл, аман уламжлал-зан үйлийн ерөнхийлсөн бүтээл болон сонин сэтгүүлд нийтлэгдсэн ерөөлүүд нь шинжааны ойрад монголчуудын ерөөлийг олон зуун жилийн турш зөвхөн амаас амд, чихээс чихэнд дамжин уламжилж байсан түүхийг жинхэнээр эцэслэж, шинжааны ойрад монголчуудын ерөөлийг нэн олон хүнд таниулж, тэдний анхаарлыг татаж, хойшдын судалгаа өрнүүлэх буюу ерөөлийн уламжлал залгамжлалд үзүүлсэн идэвхи нөлөөг энд бид үгүйсгэх үгүй. Гэвч тухайн үед аман уламжлалын шинж чанарыг бүрэн ойлгосон үгүй буюу түүнийг цуглуулан хэвлүүлэгч нарын аман уламжлалыг цуглуулан хэвлүүлэх арга онолыг бүрэн сайн эзэмшээгүйгээс болж, тэдгээр ерөөлийн цуглуулга хэвлэл өнөөгийн аман уламжлалыг олон талаас судлах хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадах үгүй болжээ.

Аман соёл ба бичгийн соёлын хамгийн их ялгаа нь уламжлалын зуучлуур нь адил үгүйд оршидог. Нэг нь амаар зууч болгодог байхад нөгөө нь үсэг бичгээр зууч болгон үеэс үед дамждаг юм. Тиймээс нэг нь цаг ямагт хөдөлдөг, хөдлөнгүй соёл байхад, нөгөө нь харин үүрд тогтонгуй байдаг, тогтворт соёл байдаг. Түүнчилэн аман соёл ба бичгийн соёлыг үсэг бичигт буулгах арга барилын талаар их зөрөөтэй байдаг. Өнгөрсний судлаачид ба бичигтэд энэхүү зөрөөг мэдэх үгүй буюу дэмий анхаарсангүйгээс болоод аман уламжлалыг буулгахдаа бичгийн уламжлалын аргыг хэрэглэн буулгаж ирсэн байна. Өөрөөр хэлбэл, ерөөлчийн ерөөснийг тэр чигээр нь бус, харин засаж өөрчлөх, нэмж хасах зэрэг олон зүйлийн аргыг хавсран хэрэглэсэн болохоор тэдгээр хэвлүүлсэн ерөөлийн текстээс бид ерөөлийн жинхэнэ чанар, үнэ өртөг ба ерөөлчийн хэв намбыг уудалж гаргахад тун хүчир болжээ.

Аман соёл бол хөдөлгөөнт чанартай байдаг тул, ямар нэгэн аман бүтээлийн ямар нэг газар оронд тархсан тархац нь жигд бус байдаг. Мөн түүнийг уламжилсан бодгаль бие болох аман уламжлагч хэдийгээр их төлөв тухайн орон нутгийн онцлог шинжийг хадгалж байдаг боловч мөн өөрийн гэсэн хэв намбатай байдаг. Энэ нь түүний оршин байгаа байгалийн орчин ахуй, эрхэлж буй ажил хөдөлмөр, аман уламжлалыг уламжилах үр мэргэжил болон хувь хүний дур сонирхол зэрэг олон талын нөхцөлөөс шалтгаалдаг. Тиймээс ерөөлийн газар орны өвөрмөц шинж, ерөөлчийн хэв намба зэргийг шинжлэн тодруулах нь тэр газрын аман уламжлалын нөөц хийгээд түүх соёлыг ойлгоход суурь дэвсгэрийн үйлдэл үзүүлдэг. 1983 онд хэвлэгдсэн “ерөөл магтаал” гэх номоор жишээлэхэд “Хажин шианий Су. Дорж эмхэтгэв”, “До. Бадмаас тэмдэглэв” гэх мэтээр ерөөлийн эх ирэлтэд тодорхойлолт хийсэн байдаг. Үүнд “Су. Дорж эмхэтгэв” гэснээс Су. Дорж ямар хүн байсан бэ?

Эрэгтэй хүмүүн байсан уу? Эмэгтэй хүмүүн байсан уу? улсын алба хашдаг хүн байсан уу? Малчин хүн байсан уу? Су. Дорж хаана, ямар газарт, хэн гэдэг хүнээс ямар цагт, ямар аргаар ерөөл тэмдэглэж авсан бэ? зэрэг асуулт тулгарна. Эндээс зөвхөн Хажин шианьд ерөөл байна гэснийг мэдэж болохоос биш, харин Хажин шианьд ямар хүн, ямар ерөөл тавидаг, ямаршуу хэв намбатай ерөөдөг гэх мэтийн мэдээг огтхон ч олж харж чадахгүй. “До. Бадмаас тэмдэглэв” гэдгээс До. Бадам ямар хүнээс ямар цагт тэмдэглэсэн гэдэг нь тодорхойгүй байж мөн тэмдэглэгч хийгээд тэмдэглэгдэгч хоёрын хүйсийн ялгал, тухайлсан ажил, ямар газрын хүн хүртэл нь тодорхой бус байж, энэ нь ерөөлийн хожмын газар орончилсон судалгаа буюу ерөөлчийн бодгаль судалгаа хийхэд балархай зүйлсийг үлдээж өгсөн байна.

Зан үйл ба аман уламжлал хоёр бол ийгээр төрсөн ах дүү хоёр юм. Ямар зан үйлийг үйлдэж байвал, түүнд нь зохицсон аман уламжлалыг бүтээж уламжилдаг. Аман уламжлалыг зан үйлээс салгавал, түүний эчнээ далдын гүн санаа, утга учрыг ойлгож мэдэхэд хүчир болно. Дээр ярьж өнгөрсөн шинжааны ойрадын ерөөлийн цуглуулга хэвлэл нь цөөн хэд нь тухайн ерөөлийн зан үйлийн уламжлалд тодорхойлолт хийснийг гаргавал бусад нь бүр зан үйлийн уламжлалаас салсан нүцгэн текст болно. Шинжааны ойрад монголчууд “гэрийн ерөөл”-г голдуу нэг бол хүүдээ бэр буулгах гэж, аав ээж ах дүү нь гэр бүрсний б дараа, гэрийн найр хийн ерөөж, бас нэг нь хуримын үед шинэ бэрээ буулгасны дараа тавьдаг. Тиймээс зөвхөн “гэрийн ерөөл”-г тэмдэглэн хэвлүүлэхэд түүний оршиж бүхий орон зайг тодотгож өг, үгүй бол тэр нь зөвхөн зан үйлийн уламжлалаас салсан өнчин текст болж бичгийн уран зохиолд Ойртох хандаш гарна.

Дээрхээс үзвэл, шинжааны ойрад монголчуудын ерөөлийн цуглуулга хэвлэлд бичгийн соёлын уламжлалын аргаар ерөөлийг засан өөрчлөн хэвлүүлэх, тэмдэглэсэн газар орон болон ерөөлч, цуглуулагчтай холбогдох мэдээ занги дутуу ба зан үйлийн уламжлалаас салсан нүцгэн ерөөлийн текст хэвлүүлэх зэрэг асуудал оршиж байгаа ба эдгээр нь ерөөлийн агуулгыг бүрэн ойлгох ба ерөөлчийн хэв намба, газар орны өвөрмөц шинж зэрэгт судалгаа хийхэд нэг хэмжээний төвөг учруулсан байна.

Хураангуйлбал, шинжааны ойрадын ерөөлийн цуглуулга хэвлэл нь 20 дугаар зууны наяд оноос эхлэн тусгай хэвлэл, аман уламжлал-зан үйлийн ерөнхийлсөн бүтээл ба сонин сэтгүүл дээр бага бус ерөөл тэмдэглэгдсэн байж, энэ нь шинжааны ойрадын ерөөлийг бусад өөр улс оронд таниулан мэдүүлэх буюу харьцуулан судалгаа хийх хийгээд хожим ирээдүйд өвлөн уламжлахад чухал нэмэр оруулсан идэвхитэй ажил болжээ. Гэвч цуглуулагч ба хэвлүүлэгчийн аман уламжлалын уг чанар ба цуглуулан эмхтгэх арга барилын талын онолын мэдлэг дулимгаас болж, ерөөлд холбогдох зан үйл, ерөөлчтэй холбогдох мэдээ сэлт зэргийг ерөөлийн цуглуулга хэвлэлдээ оруулсангүй нь ерөөлийг одоогийн аман уламжлалын хараанаас судлан шинжилэхэд нэг хэмжээний харш саад учруулсан гэдэг нь тодорхой байна.

Ном зүй

Ерөөл магтаал (тод үсгээр). Шинжааны ардын хэвлэлийн хороо, 1980.

Ерөөл магтаал (тод үсгээр). Шинжааны ардын хэвлэлийн хороо, 1983.

Жангарч Жуунаагийн гар бичмэл текст (нэг). У. Тайван буулган тайлбарлав. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2015.

Норжим И. Ерөөл магтаал-нэг нас, Ховогсайрын ардын аман зохиол (тод үсгээр). Шинжааны сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 2016.

Ойрад монголын ерөөл магтаал. Цэцэнмөнх, Гэрэлцэцэг эмхэтгэж найруулав. Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1993.

Ховогсайрын монгол ардын аман зохиолын дээж. Нү. Зоригтой эмхэтгэн найруулав. Шинжааны ардын хэвлэлийн хороо, 2004.

Ховогсайрын ерөөл магтаалын эмхэтгэл. Шинжаангийн сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 2010.

Цахар ардын ерөөл магтаалын чуулган. Ц. Гэрэлбаатар, Ша. Хишигманлай эмхэтгэн найруулав. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2014.

Цахарын шинэ ерөөл магтаал. Ц. Гэрэлбаатар эрхлэн найруулав. Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 2015.

Шинжааны монгол ардын дуу шүлгүүд. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1959.

Шинжааны өөлдүүдийн зан үйл (тод үсгээр). БНХАУ-ын Улс төрийн зөвлөлгөөний Монголхүрээ шианий салбар зөвлөлөөс эмхэтгэн найруулав. Шинжааны шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2011.

Га. Гомбо. Гурван булагт ерөөл // Шинжааны өдрийн сонин (монгол хэвлэл). 1983 оны 8 сарын 23-ны өдөр, 4 дүгээр нүүр.

Ө. Чүлтэм. Ерөөл // Шинжааны өдрийн сонин (монгол хэвлэл). 1983 оны 8 сарын 23-ны өдөр, 4 дүгээр нүүр.

Т. Од. Шинэ ерөөл // Үүрийн цолмон. 1985 оны 2 дугаар хугацаа.

У. Басан. Шинэ жилийн ерөөл // Шинжааны өдрийн сонин (монгол хэвлэл). 1984 оны 1 сарын 1-ий өдөр, 4 дүгээр нүүр.

Цагаан сарын ерөөл. Буянтогтох эмхэтгэв // Шинжааны өдрийн сонин (монгол хэвлэл). 1982 оны 1 сарын 24-ний өдөр, 4 дүгээр нүүр.

Хошуудын гэрийн ерөөл. Бу. Мөнх эмхэтгэв // Хан тэнгэр. 1987 оны 3 дугаар хугацаа.

Хуримын ерөөл. Зус хадгийн ерөөл. Даш өвгөнөөс тэмдэглэсэн // Хан тэнгэр. 1991 оны 3 дугаар хугацаа.

Хажин шианий ардын ерөөлүүдэс. Сү. Дорж эмхэтгэв // Үүрийн цолмон. 1986 оны 6 дугаар хугацаа.